

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 07 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат төсвийн тодотголын хүрээнд 60 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилтийг танахгүй байх боломжтой эсэх, эрүүл мэндийн байгууллагын урсгал зардал, Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал, хүүхэд хамгааллын санхүүжилтээс танаж байгаа эсэх, төрийн албан хаагчийн цомхотголын талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат төрийн албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмжийн төсөв болон төрийн албаны цомхотголын хүрээнд ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг хассан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах, хүүхэд хамгаалал, хөгжлийн хүрээнд шаардлагатай санхүүжилт тусгагдсан эсэх, орчин үеийн хөдөлмөрийн чиг хандлагад нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд эрүүл мэндийн салбарт хэмнэлт хийсэн нь зөв эсэх, орон нутагт олгож байгаа санхүүгийн дэмжлэгийг хассантай холбогдуулан тендер зарлаж гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээг хэрхэн зохицуулах талаар, төсвийн хэмнэлтийн хүрээнд зардал танахдаа ач холбогдлоор нь тодорхой эрэмбэ тогтоон хасах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа тодотголыг хийхдээ салбарын үр ашгийг дээшлүүлэх хүрээнд тооцоо, судалгаа гаргасан эсэх, Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг хассантай холбогдуулан шаардлагатай ямар бодлогын арга хэмжээг авах талаар, Улсын Их

Хурлын гишүүн Б.Бейсен Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын санхүүжилтэд шаардлагатай нэмэлт төсвийг тусгах боломжтой эсэх, эрүүл мэндийн салбарын төсвийг танахгүй байх талаар авсан арга хэмжээ, эрүүл мэндийн салбарын урсгал зардлыг оновчтой тооцоолох талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт танагдсан төсвийн талаар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

 **Л.ЭНХНАСАН**

